

1

ЭРЭЛТИЙГ ДЭМЖИЖ Л ХЯМРАЛААС ГАРНА

Б.Батмөнх

“ Эдийн засгийн ухаан нь сая сая хүний хувь заяанд нөлөөлөх шийдвэрт хүргэдгээрээ гайхамшигтай. Эдгээр шийдвэр нь зөвхөн их эдийн засагчдын үзэл бодол, онол дээр үндэслэсэн байдаг.”

Ж. М. Кейнс

Абстракт: Энэхүү эрдэм шинжилгээний өгүүлэлд өнөөдөр дэлхий даяар улам газар авч байгаа санхүү, эдийн засгийн хямралын өмнөх Монгол Улсын эдийн засгийн байдалд товч үнэлгээ өгч, уг хямрал манай орны эдийн засагт хэрхэн нөлөөлж байгааг харуулж, түүнийг даван туулах талаар баримтлах онол, үзэл номлол, хямралын эсрэг хэрэгжүүлэх практик арга хэмжээний саналыг дэвшүүлсэн.

1. Монголын эдийн засаг хэдийнээ хямарчихсан байсан

Өнөөдөр дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын тухай, түүний эсрэг улс орнуудын засгийн газруудаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний тухай хангалттай бичиж байна. Харин манай орны хувьд энэхүү хямрал хэрхэн нөлөөлж байгааг анхааралтай судлан үзэж, түүний эсрэг авах арга хэмжээг онол, практикийн өндөр түвшинд шинжлэх ухааны үндэслэлтэй зөв тодорхойлох шаардлага эдийн засгийн бодлогын нэн тулгамдсан асуудал болж байгаа юм.

Бид дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын Монгол Улсад үзүүлж байгаа нөлөөг шинжиж, цаашдын оношыг оновчтой тодорхойлохын тулд манай орон хямралын өмнө ямар байсныг авч үзэх шаардлагатай. Өнөөдөр бол бидний өчигдрийн үргэлжлэл байдаг учраас энэ нь бодит байдалд илүү нийцсэн, үнэн зөв үнэлгээ өгөхөд бидэнд туслах болно.

Манай эдийн засаг нь шилжилтийн үеийн хүнд бэрх үеийг давж, зах зээлийн эдийн засгийн үндэс суурийг баттай тавьж эхэлсэн үедээ ороод байгаа түүхэн цаг үед дэлхийн санхүү, эдийн засгийн хямралтай анх удаа нүүр тулан учирч байгааг та бид харж байна. Монгол Улсад төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийг шилжилтийн хамгийн таарууханд тооцогдож байгаа ” цочир

эмчилгээний” загвараар нурааж, түүний суурин дээр зах зээлийн эдийн засгийн цоо шинэ харилцааг төлөвшүүлэх арга замаар сүүлийн 18 жилийг туулсан билээ. Манай орны хувьд шилжилтийн үеийн эдийн засгийн бодлогын гол үзэл баримтлал нь Олон Улсын Валютын Сангаас шилжилтийн орнуудад явуулж ирсэн бодлого байсан билээ. Энэ бодлогын гол зорилго нь өмч хувьчлалыг богино хугацаанд явуулж, хуучин улсын өмчийг хувьд шилжүүлж, дотоод зах зээлийг дэлхийд нээлттэй болгож, үнийг чөлөөлөх явдал байсан. Энэ үед Монгол Улс улс төрийн хувьд хуучин ЗХУ-ын нөлөөллөөс гарч, шууд АНУ тэргүүтэй барууны их гүрнүүдийн нөлөөлөлд орсон тул энэ шинэчлэлтийг өөрөө толгой мэдэн хэрэгжүүлэх эрх мэдэлгүй байлаа. Энэ нь нэгэнт эдийн засгийн хувьд маш хүнд байдалд орсон Монгол Улс Олон Улсын Валютын Сан зэрэг олон улсын эдийн засаг, санхүүгийн байгууллага, хандивлагчдын мөнгө хөрөнгийг авч, тэдний заавар зөвлөлгөөг дагахаас өөр гарц байгаагүй юм. Ийм хувь тавилан зөвхөн Монголд бус шилжилтийн олон оронд тохиосон билээ.

Энэхүү бодлогын үр дүн нь юу болов гээд 18 жилийн дараа эргээд харахад хэтэрхий яаравчилсан, үр дагаварыг нь дутуу тооцсон өмч хувьчлалын үр дүнд эдийн засгийн үндэс суурь болсон хуучин улсын өмчтэй байсан аж ахуйн нэгжүүд үгүй болж, олон мянган ажилгүйчүүд шинээр төрөн гарч, Монголын нийгэмд урьд өмнө байгаагүй ядуурал газар авсан билээ. 1990 – ээд оноос эхэлсэн энэ байдал одоо ч хадгалагдан үлдэж, үе үеийн Засгийн газар ядууралтай тэмцэж, түүнийг бууруулах олон тооны хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлсээр ирсэн боловч сүүлийн 18 жилд үе шаттайгаар чөлөөлсөн үнэ, энэ хугацаанд үргэлжилсэн инфляцийн өсөлтийн улмаас ядуурал буураагүй байгаа нь бодит үнэн билээ.

Өнгөрсөн 18 жилд Монгол Улс эдийн засагаа дэлхийн аль ч улс оронд байгаагүй хэмжээгээр бүр цэлийтэл нь нээсэн. Үүний тод жишээ нь 1996 онд Монголын Засгийг газар бүр гаалийн татвараа тэглэж байсан явдал юм. Үр дүн нь юу болов гээд үзэхэд гадаадын хямдхан, гол төлөв чанаргүй бараагаар дотоодын зах зээл дүүрч, арай ядан өндийх санаатай оролдож эхэлсэн үндэсний үйлдвэрүүдийг хямд үнэтэй ижил төрлийн бараа цохиж унагасан. Монголын эдийн засагт ёстой тэнцвэргүй өрсөлдөөн болж, хөл дээрээ босоогүй байсан үндэсний нялх үйлдвэрлэл босох нөхцөлгүй хүнд байдалд орсон. Энэ байдал одоо ч үргэлжилж, үндэсний үйлдвэрлэлээ сэргээе гэсэн оролдлого энэхүү хана хэрмэнд тулаад сөхөрч байна. Одоо жижиг, дунд үйлдвэрлэлийг орон нутагт хөгжүүлэх талаар их ярьдаг болсон боловч цаана нь нөгөө л айхтар хана хэрэм босоотой байгааг олж харахгүй л байна. Эдгээр бодлогын үр дүнд Монгол Улсыг үйлдвэргүйжүүлэх үйл явц үргэлжилсээр ирсэн бөгөөд харин энэ Засгийн газар үйлдвэржүүлэх зорилтыг сэргүүлж тавьсан нь зоригтой, шийдвэртэй алсын хараатай бодлого юм.

Монгол Улс зах зээлээ цэлийтэл нээснийхээ үр дүнд импортоос хүчтэй хамааралтай маш эмзэг эдийн засагтай улс болсон нь одоо нэгэнт тодорхой болжээ. Өнөөдөр манай улс өргөн хэрэглээний барааныхаа 70 хувийг, шатахуун, үр тариа гэх мэт стратегийн зориулалттай бараа,

бүтээгдэхүүнийхээ 50-100 хувийг зөвхөн импортоор хангадаг, эдгээр бараа бүтээгдэхүүнээр импортлогч орнуудаасаа хараат болсон. Одоо бүр сүүлдээ оросууд шатахууныхаа үнийг хэзээ хичнээн хувиар нэмэхийг зүгээр хараад сууж байдаг өрөвдөлтэй улс болсон билээ. Импортоос хамааралтай байдал 2007 оны зун хятадын цементийн үнэ нэмэгдэхэд орон сууцны үнэ дагаад хэрхэн өссөнөөр тодорхой харагдсан. Дараа нь 2008 оны зун, намар дэлхийн зах зээл дээр үр тариа, шатахууны үнэ эрс өсөхөд Монголын эдийн засаг инфляцийг шууд импортолж эхэлсэн билээ. Инфляцийн жилийн дундаж өсөлт 2008 онд 28 хувь хүрсэн нь 1992 оноос хойш гараагүй өндөр өсөлт байв. Энэхүү инфляцын дараагаар Засгийн газраас цалин, орлогыг индексжүүлж, нэмэгдүүлээгүй тул хүн амны худалдан авах чадвар эрс буурч, ядуурал улам гүнзгийрэхэд хүргэж байна. Өөрөөр хэлбэл, 2007 оны дундаас эхэлсэн инфляцийн өсөлт хямралын өмнөх Монголын хүн амын худалдан авах чадварыг эрс багасгасан байлаа.

Ингээд инфляци нэмэгдэхийн хирээр Монгол банк хариу арга хэмжээ болгож мөнгөний бодлогоо чангаруулж, мөнгөний нийлүүлэлтийг багасгах зорилгоор арилжааны зээл олгохыг хязгаарлах бодлого явуулж эхэлсэн. Энэ нь маш хор уршигтай үр дагавар авчирч, хөрөнгө оруулалт эрс хумигдаж, бизнесийн үйл ажиллагаа бүхэлдээ зогсонги байдалд орсон. Баригдаж байсан олон зуун барилга зогсож, тэдэнд өмнө олгосон арилжааны банкны зээл түгжигдсэн. Одоо ч энэ байдал үргэлжилсээр дээр нь төв банкны бодлогын хүүг нэмэгдүүлсэн нь арилжааны банкнуудын зээлийн хүү өсөхөд хүргэж, бизнесийн орчин нөхцөл улам доройтож, хөрөнгө оруулалт буурахад шууд нөлөөлж байна. Жижиг орны эдийн засаг АНУ-ын долларын ханшид нөлөөлж төдийлөн чадахгүй гэдгийг манай банкны удирдлага мэддэг баймаар юм. Долларын ханшийг дотооддоо унагах гэж Монгол мэтийн жижиг орон зээлийн хүүгээ өсгөх замаар оролдох нь арслангийн сүүлээр оролдсон хулгана гэсэн л үг юм. Гэхдээ энэ арга хэмжээг шүүмжлэхээс өмнө нөгөө л Олон улсын валютын сангаас тусламж авах болоод аргагүй тулгалтанд орж ийм арга хэмжээ авсан гэж ойлговол үнэнд илүү нийцэх байхаа. ОУВС-ын энэхүү бодлого нь зээлийн хүүгийн хэмжээ өсөхөд тухайн улс уруу хөрөнгө оруулалт урсан ордог, хүүгийн хэмжээг өсгөхгүй бол валютын ханш унаж, доллараар илэрхийлэгдэх өр төлбөрийг хийж чадахгүй байдалд ордог гэдэг үзэл баримтлалд тулгуурладаг. Үнэн хэрэг дээрээ өндөр хүү нь зээл ихтэй компаниудын санхүүгийн байдлыг доройтуулж, улмаар дампууруулдаг нь олон улсын практикаас тодорхой байдаг. Өндөр хүү нь хүнд байдалд орсон компаниудын тоог нэмэгдүүлж, эргэж зээлээ төлөх чадваргүй компаниуд олширч, арилжааны банкууд өөрсдөө суларч эхэлдэг.

Нобелийн шагналт, орчин үеийн нэрт эдийн засагч Ж. Стиглиц 1997-1998 онуудад Зүүн Азийн орнуудад болсон эдийн засгийн хямралын үед ОУВС –гаас эдгээр орнуудад зээлийн хүүгээ 50 дахин өсгө гэж шаардаж, буруу бодлого явуулсныг шүүмжилсэн байна (4, хуудас 160.). Сүүлийн үед ОУВС –ын үйл ажиллагааг эрдэмтэд төдийгүй Их Британы Ерөнхий сайд Горден Браунаас эхлээд олон нэрт улс төрчид шүүмжилж байгаа. Зүүн Азийн хямралын үед

явуулсан ОУВС-ын бодлого байдлыг улам хүндрүүлсэнийг эдийн засагч Ж. Стиглиц хурц шүүмжилсэнийг анхааралдаа авах ёстой.

Ж.Стиглиц дэлхий даяар сүүлийн 25 жилд болсон 100 орчим хямралын шалтгааныг судлаад санхүүгийн зах зээл, хөрөнгийн бирж нь сайн хөгжөөгүй орнууд хөрвөх чадвартай капитал аа чөлөөлсөн нь хямралд хүргэх гол шалтгаан болсныг тогтоожээ. Энэ нь хөрөнгө оруулагчдын ааш араншингийн гэнэтийн өөрчлөлттэй холбоотой. Дотоод, гадаадын хөрөнгө оруулагчид оруулсан хөрөнгөө гэнэт гадагш нь татахад хөгжиж байгаа бага эдийн засаг тэсдэггүй хямралд өртдөг байна. Наяад оны сүүл 90-ээд оны эхээр ОУВС-гаас тулгаж ирсэн бас нэг шаардлага нь хөрөнгийн зах зээлээ чөлөөлөх нээлттэй болгох явдал байжээ. Тэгэхлээр бид ийм алдааг давтах ёсгүй.

Өмнө дурьдсан буруу үйлдэл, арга хэмжээний зэрэгцээ Монголын төрөөс 2006-2008 онд явуулж ирсэн төсвийн бодлого ихээхэн алдаатай байсан нь хямралд өртөхөд улам хүнд туссан. 2006 оноос хэрэгжүүлж эхэлсэн 68 хувийн татварын орлогын өсөлтөөр Засгийн газрын зардлыг эрс нэмэгдүүлж, нийгмийн халамжийн арга хэмжээнд бэлэн мөнгийг хавтгайруулан олгож, хүн амын гар дээрх мөнгөний хэмжээг өсгөсөн зэрэг нь дотооддоо инфляцийг нэмэгдүүлэх нөхцөл болсныг бас дурьдахад илүүдэхгүй. Одоо нэгэнт өндөр авчихсан төсвийн зардлаа танах гэж Засгийн газрын гишүүд толгойгоо гашилгаж сууна. Энэ бол үйл явцыг урьдчилж хардаггүй, харин ниргэсэн хойно нь хашгирдаг монгол араншин юм.

Энэ бүхнээс харахад Монголын эдийн засаг дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал манайд орж ирж нөлөөлөхөөс өмнө өөрөө дотроо аль хэдийнээ хямарчихсан байсан харагдаж байгаа юм. Харин 2009 он гарсаар долларын ханш чангарч, төгрөгийн ханш суларсан нь импортоор өргөн хэрэглээний болон үйлдвэрлэлийн хэрэгцээт бараа, бүтээгдэхүүнээ хангадаг манай орны хувьд байдлыг улам хүндрүүлээд байна.

2. Монголын эдийн засагт үзүүлж байгаа хямралын нөлөө

1997-1998 онуудад Зүүн Азийн орнуудад эхэлж улмаар Орос, Латин Америкийн орнуудыг хамарсан эдийн засгийн хямрал манай оронд үндсэндээ нөлөө үзүүлээгүй билээ. Дэлхийн үнэт цаас, санхүү, хөрөнгийн зах зээлд бараг оролцдоггүй манай орны хувьд энэхүү хямрал бусад орнууд шиг сонгодог байдлаараа хүчтэй нөлөөлөхгүй, харин арай өөр арга замаар нөлөөлж байгаа нь харагдаж байна.

Дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал ямар арга замаар, ямар сувгаар манай эдийн засагт нөлөөлж байгааг судлах явдал нь түүний эсрэг хариу арга хэмжээг боловсруулахад чухал ач холбогдолтой юм. Энэхүү хямрал гадаад, дотоод гэсэн 2 гол чиглэл, сувгаар нөлөөлж байна гэж үзэж болно.

А.Гадаад хүчин зүйлд:

1. Нэгэнт импортоос хүчтэй хамааралтай эдийн засаг учраас манай эдийн засаг дэлхийн зах зээлийн үнийн өсөлтийг импортоор хүлээн авч байна. Энэ нь хямралын өмнөх үед гол төлөв хамаарч байсан. Гэхдээ хямралын энэ үед дэлхийн зах зээлд үнийн өсөлт биш, харин бууралт ихэвчлэн явагдаж байна.
2. Дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын нөлөөгөөр манай орны экспортын цөөн бүтээгдэхүүний эрэлт багасаж, дэлхийн зах зээлийн үнэ нь буурсанаас экспортын орлого багасаж, төлбөрийн тэнцэлийн алдагдлыг өсгөх замаар хямрал орж ирж байна. Төлбөрийн тэнцэл их алдагдалтай гарч байгаа нь Монгол Улсын данс улайж, санхүүгийн хүндрэл учирсныг харуулж байна. Энд бас мал аж ахуйн гаралтай экспортын түүхий эдийн үнэ буурсан нь малчдын орлого буурахад хүргэв.
3. Гадаадад ажиллаж, амьдарч монголчуудын орлого багассанаас ар гэртээ явуулдаг мөнгөн гуйвуулга багасаж, төлбөрийн тэнцлийн алдагдлыг нэмэгдүүлж, уг орлогоор амьдралаа залгуулдаг олон мянган айл өрхийн амьжиргаа доройтоход хүрч байгаа нь хямралын бас нэг нөлөөлөх суваг болж байна.
4. Гадаад эх үүсвэрээс орлого, үйл ажиллагаа нь хамаардаг дотоодын аж ахуйн нэгжүүдийн орлого эрс багасаж байгаа нь хямралын нөлөөлөх өөр нэг суваг болж байна. Тухайлбал, Улаанбаатар төмөр замаар Орос, Хятадын хооронд дамжин өнгөрдөг ачааны хэмжээ эрс багассанаас энэ байгууллагын орлого буурч, санхүүгийн хүндрэлд орсон. Агаарын тээврээр зорчих гадаадын иргэдийн тоо ч буурах хандлагатай байна. Энэ нь аялал жуулчлалын салбарын орлого багасахад хүргэх болно. Гадаад орнуудын санхүүгийн зах зээл дээр өрнөсөн хямралын улмаас манай томоохон арилжааны банкнуудын гадаадаас татахаар төлөвлөсөн 400 сая орчим ам. долларын гэрээ хэлцлүүд хойшлох, улмаар хэрэгсэхгүй болгосон баримт байна.¹ Засгийн газраас гадаад орнуудтай хэрэгжүүлэхээр тохиролцсон зарим төсөл, арга хэмжээнүүд хойшлогдож болзошгүй байна.

Бид хямралын нөлөө, үр дагаварыг дан ганц гаднаас хайх нь буруу мэт санагдана. Манай санхүү, мөнгө, төсвийн бодлого оновчтой үр дүнтэй байгаагүй нь үүнийг нотолдог. Дотоод хүчин зүйл гадаад нөлөөнөөс багагүй байж болохоор байгааг анхаарууштай.


¹ Б. Энххуяг, “Монгол банк мөнгөний бодлогыг зөөллөх арга хэмжээ авна”

Б.Дотоод хүчин зүйлд

1. Өнгөрсөн жилүүдийн байдлаас харахад дотооддоо санхүү, төсөв, мөнгөний ямар бодлого явуулахаас хямралын эдийн засагт үзүүлэх нөлөө ямар байх нь тодорхой харагдаж байна.
2. Хямралыг далимдуулан ашиг хонжоо олох гэсэн хүмүүс, улс төр, бизнесийн бүлэглэлүүд байгааг анхаарахгүй байж болохгүй юм. Эдний үйлдэл нь хямралыг улам даамжруулж болох талтай. “Анад” банкны дампуурал үүний тод жишээ юм. Анад банк бол хямралын сургаар л дампуурсан. Тэдний төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд арилжааны зээлийг их хэмжээгээр замбараагүй олгосон нь ийм байдалд хүргэснийг тэнд хийсэн шалгалт харуулсан.
3. 2009 он гарсаар дотоодод валютын хомсдол үүсч, долларын эрэлт нэмэгдэж, түүний ханш огцом чангарч, төгрөгийн ханш эрс унаж, хямралт байдалд улам нэрмээс болсон. Үүний улмаас импортоор оруулж ирсэн өргөн хэрэгцээний бараа, бүтээгдэхүүний үнэ өсөх нөхцөл бүрдсэн. Валютын ханш тогтворгүй байгаагаас бизнес эрхлэгчдэд хүндрэл учирч, ханшны тогтворжилтыг хүлээсэн байдал үүсч, бизнес бүхэлдээ зогсонги байдалд орсон.
4. Манай зарим компани Монголоос их хэмжээний доллар гадаадад гаргасан байж болзошгүй мэдээлэл байдаг. Долларын ханш огцом өссөн 2009 оны 2-3 –р сард хэвлэл мэдээллийн хэрэгслээр Мобиком компани их хэмжээний валютыг гадагш нь шилжүүлсэн мэдээлэл цацагдаад өнгөрсөн. Хэрэв энэ үнэн бол хямралт байдалд тос нэмсэн үйл ажиллагаа юм. Өмнөд Солонгост хямрал нүүрлэсэн шалтгаан нь үнэндээ ийм байсан билээ. Санхүүгийн зохицуулах хороо үүнийг шалгах шаардлагатай байна.

Дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын нөлөө улс орнуудын эдийн засгийн өсөлт саарч байгаагаар юуны өмнө илэрч байгаа билээ. Энэ байдал манай орны эдийн засагт ч мөн ажиглагдаж байгааг статистикийн тоо баримт харуулж байна. 2007 онд 10 хувьд хүрсэн ДНБ –ний өсөлт 2008 онд 8,9 хувьтай гарлаа. Хүснэгт 1-д 2008 оны ДНБ-ний өсөлтийг улирлаар, өмнөх оны мөн үетэй харьцуулан харуулав. Хүснэгтээс харахад 2008 оны ДНБ-ний өсөлт жилийн явцад илэрхий саарч иржээ.

Хүснэгт 1. 2008 оны дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт, улирлаар



2008 оны дүнгээр гадаад худалдааны алдагдал 1 тэрбум 76.5 сая ам. долларт хүрчээ. Ийм их хэмжээний алдагдал хэзээ ч гарч байгаагүй юм. Энэ бол төлбөрийн тэнцэлд шууд нөлөөлж, түүний алдагдал урьд байгаагүй хэмжээнд хүрч, түүнийг валютынхаа жаахан нөөцөөр хаана гэсэн үг юм. 2007 онд манай улс 607.8 мянган тонн зэсийн баяжмал экспортолсон бол 2008 онд 582,9 мянган тонн болж, 4.1 хувиар буурчээ. 2009 оны эхний 2 сарын дүнгээр бас л экспортод гаргасан зэсийн баяжмалын хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 5.7 мянган тонноор буурчээ.

Зэсийн үнэ унаж, экспортын орлого буурснаас 2008 оны нэгдсэн төсвийн алдагдал 305.7 тэрбумд хүрчээ. Сүүлийн жилүүдэд ашигтай гар ирсэн төсөв ихээхэн хэмжээний алдагдалтай гарлаа. Одоо 2009 оны эхний 2 сарын дүнгээр нэгдсэн төсөв 112,2 тэрбум төгрөгийн алдагдалтай гараад байна. Зөвхөн эхний улиралд ийм алдагдалтай байгаа манай төсөв 2009 оны дүнгээрээ урьд 2008 оноос ч илүү их алдагдалтай гарах магадлалтай байна.

2008 онд эдийн засагт эргэлддэг бэлэн болон бэлэн бус мөнгөний нийт дүн болох M2 үзүүлэлт 2007 оныхоосоо анх удаа 60 тэрбум төгрөгөөр буурсан байна. Энэ бол эдийн засаг, бизнесийн үйл ажиллагаа нэлээд хумигдсаны шинж тэмдэг юм. 2009 оны 2 –р сарын эцэст байсан хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2008 оны эцсийнхээс 1.5 дахин нэмэгджээ. Манай компаниудын төлбөрийн чадвар эрс буурсаныг энэ баримт харуулж байна.

12. Хямралын талаарх онол, номлол ба практик

Өнөөгийн дэлхийн эдийн засаг, санхүүгийн хямрал цар хүрээгээрээ 1929-1933 оны их хямралын хэмжээнд дөхөж очих төлөвтэй байна. Наяан жилийн өмнө болсон энхүү хямралаас хүн төрөлхтөн олон чухал сургамж авсаны зэрэгцээ эдийн засгийн онолын үзэл баримтлалд ч их өөрчлөлт орсон түүхтэй. Энэ бол ХХ зууны суут эдийн засагчдын нэг Ж.М. Кейнсын үзэл номлол байсан юм. Өнгөрсөн зууны 20-иод оны сүүлчээр болсон их хямрал өнөөгийн хямралаас тэс өөр, орчин нөхцөл нь өөрчлөгдсөн гэх хүн гарч мэднэ. Үнэн

хэрэг дээрээ 80 жилийн тэртээ болсон их хямралын сургамжаас авах юм одоо ч байсаар л байна.

XX зууны 20-иод оныг хүртэл тэр үеийн өндөр хөгжилтэй орнуудад зах зээлийн эдийн засаг нь өөрөө өөрийгөө бүрэн зохицуулах чадвартай, эрэлт нийлүүлэлтийн тэнцвэр өөрөө бүрэлдэн тогтдог гэдэг үзэл номлол ноёлж байсан бөгөөд харин энэхүү номлолыг их хямралын дараа зайлшгүй эргэн харахад хүрч, хэт үйлдвэрлэлтийн хямралаас зайлсхийхын тулд зах зээлд төрөөс зохицуулалт хийж, эрэлт, нийлүүлэлтэд нөлөөлөх шаардлагатай гэдэг номлолд шилжсэн билээ.

Тэр үеийн хөгжингүй капиталист орнуудаас их хямралыг даван туулах талаар 20- иод оны сүүл 30 –аад оны эхээр хуримтлуулсан туршлага болон өөрийн судалгааны үр дүнгээр Ж.М. Кейнс “Ажил эрхлэлт зээлийн хүү, мөнгөний ерөнхий онол ” гэдэг алдарт зохиолоо 1936 онд хэвлүүлсэн билээ. Тэрээр энэхүү бүтээлдээ эдийн засгийн хямралтай тэмцэх гол арга хэрэгслийг зах зээлийн эдийн засаг дахь төрийн оновчтой зохицуулалт, “үр ашигтай” эрэлтийг бүх талаар дэмжих явдал гэж үзэж байсан юм. “ Үр ашигтай” эрэлтийн талаарх энэхүү номлол макро эдийн засгийн шинжилгээг шинэ түвшинд гаргаж, эдийн засгийн систем бүхэлдээ хэрхэн ажилладаг, үйлдвэрлэж, хуваарилж, дахин хуваарилаж, хэрэглэж байгаа орлогууд хэрхэн хөдөлж, урсаж байгааг тайлбарлах боломж олгосон билээ. Төрийн зохицуулалтыг хэрэгжүүлэх үндсэн хөшүүрэг нь төсвийн бодлого гэж тэрээр үзэж байлаа.

Үнэхээр ч дотоодын нийт бүтээгдэхүүнийг (ДНБ) эцсийн ашиглалтын хэлбэрээр нь $Y=C+I+X-M$ гэж үздэг (Энд Y - ДНБ, C - улсын ба хүн амын хэрэглээ, I -нийт хуримтлал, хөрөнгө оруулалт, X - экспорт, M -импорт) энэхүү тэнцэтгэлээс эдийн засгийг тэлж өсгөхөд хэрэглээ, хөрөнгө оруулалтыг дэмжих нь зайлшгүй хэрэгцээтэй бөгөөд тэдгээрээс ДНБ-ний өсөлт шууд хамааралтай байгаа тодорхой харагддаг. Харин гадаад худалдаа нь ихэвчлэн алдагдалтай гардаг манай орны хувьд цэвэр экспорт ($X-M$) ДНБ –д эерэгээр нөлөөж чадахааргүй байгаа юм. Дээрх тэнцэтгэлийг $Y+M=C+I+X$ болгон өөрчлөхөд $Y+M$ буюу үйлдвэрлэл, импортын нийлбэр нь нийт нийлүүлэлт, харин $C+I+X$ нь нийт эрэлт болно. Харин үүнээс $C+I$ нь дотоод эрэлт, X нь экспорт буюу гадаад эрэлт билээ. Санхүү, эдийн засгийн хямралтай өнөөгийн нөхцөлд улс орнуудын экспорт буюу гадаад эрэлт ихээхэн буурч байгаа бөгөөд энэ нөхцөлд төрөөс гагцхүү улс орны эдийн засгийн дотоод эрэлтээ нэмэгдүүлэх, бүрэн ажил эрхлэлтэд хүрэх бодлогыг явуулах нь зайлшгүй болох нь эндээс харагддаг. Нөгөө талаар нийт хэрэглээ нь улсын ($C_{gov.}$) ба хувийн ($C_{priv.}$) хэрэглээнээс бүтдэг тул $C = C_{gov.} + C_{priv.}$ гэж бичвэл төрийн байгууллагын хэрэглээг нэмэгдүүлэх нь мөн л эрэлтийг дэмжсэн хэрэг болно.

Кейнсын онолоор төрийн байгууллагуудын зардлыг нэмэгдүүлэх нь үндэсний цэвэр бүтээгдэхүүний өсөлтөд хүргэдэг. Бидний дээрх томъёоноос төрийн байгууллагуудын хэрэглээ ДНБ хоёр шууд хамааралтай байгааг харж болно. Кейнс төрийн байгууллагуудын зардал нь үржүүлэгч нөлөөтэй гэж

үзэж байсан. Үржүүлэгч нөлөө гэдгээ тэрээр зардлын өсөлт нь татварын өсөлтөөс илүү хүчтэй нөлөө үзүүлж байдгаар тайлбарласан.

Гэхдээ Монгол Улс ядуу жижигхэн орон мөртлөө төрийн зардал нь харьцангуй өндөр байгаа тул төрийн байгууллагуудын үр ашиггүй зардлыг хэмнэж, харин төсвийн хөрөнгө оруулалтыг бууруулахгүй байх, хүн ам, хувийн хэвшлийн хэрэглээг бүх талаар дэмжих бодлогыг явуулах нь илүү зохистой гэж үзэж байна.

Кейнсын онолоор хөрөнгө оруулалт хийхээсээ илүү хуримтлуулах хүсэл эрмэлзлэл нь амжилтанд хүргэдэггүй. Учир нь хангалтгүй нийт эрэлт нь үйлдвэрлэлийг бууруулж, түүгээр дамжин ажилгүйдэл нэмэгдэхэд хүргэдэг. Ажилгүйдлийн өндөр түвшинд хүргэдэг эрэлтийн энэхүү хомсдлыг гэтлэн давахын тулд Кейнс төрөөс хөрөнгө оруулалтын идэвхтэй бодлого явуулахыг уриалж байсан билээ.

Энэхүү бүтээлд түүний дэвшүүлсэн олон санаа, онолын дүгнэлтүүд одоо ч ач холбогдлоо алдаагүй байгаа нь өнөөдөр өндөр хөгжилтэй орнуудын засгийн газруудаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд бэлхнээ харуулж байна.

АНУ конгресс эдийн засгийнхаа өсөлтийг дэмжих зорилгоор 700 тэрбум ам. долларын санхүүжилтийг батлав. Түүнчлэн хэрэглэгчдэд зээлийг тогтвортой олгох зорилгоор тус улсын төв банк бодлогын хүүгээ бууруулсаар байна. Канадын төв банк зээлийн хүүг бууруулснаар эдийн засгийнхаа өсөлтийн хангах зорилт тавьж байна. Их Британи Улс жижиг, дунд үйлдвэрлэл, иргэдээ татварын бодлогоор дэмжиж, банк, санхүүгийн салбартаа дэмжлэг үзүүлсээр бизнесийн салбарт олгох зээлийг нэмэгдүүлэх бодлого баримталж байна. Манай өмнөд хөршийн Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг дэлхий нийтээр анхааралтай ажиглаж байна. Учир нь Хятад Улсын эдийн засгийн бодлого, арга хэмжээ нь үнэхээр амжилтанд хүргэсээр ирсэнд оршино. Хятадууд гадаад эрэлт нь багасаж экспортын орлого нь буурсан тул дотоодын эрэлтээ нэмэгдүүлэх, дэмжих, дотооддоо үйлдвэрлэл, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх бодлого явуулж байна. Хятадын банкууд зээл олголтоо нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтыг өргөтгөхөд дэмжлэг үзүүлж байна. Энэ бүхнээс үзэхэд хямралын үед “үр ашигтай” эрэлтийг бүх талаар дэмжих Кейнсын номлолыг одоо ч улс орнууд баримталсаар байгаа нь тодорхой байна.

Кейнсын онолыг шүүмжилж, 70 – аад оны дунд үеэс гарч ирсэн гэсэн Мильтон Фридманы монитарист онол эдийн засаг, инфляцыг зөвхөн мөнгөний нийлүүлэлтээр хянаж болно. Төрийн зардлыг өсгөхгүй байх нь эдийн засгийн хөгжлийн гол үндэс мөн гэсэн энэхүү онол өнөөдөр хүртэл ОУВС, Дэлхийн Банкны макро эдийн засгийн албан ёсны бодлогын үндэс хэвээр байгаа юм.

Монгол Улсын хувьд монитарист онол тэр бүр таардаггүй байсныг өнгөрсөн он жилүүд тодорхой харуулсан. Яагаад гэвэл 1990 –ээд оны дундаас өнөөг хүртэл мөнгөний нийлүүлэлт жилд дунджаар 30 гаруй хувиар, зарим жилд 40 хувьд хүрч байсан боловч инфляци тэр хэмжээгээр өсөөгүй, ихэнхдээ нэг оронтой тоонд л багтсаар ирсэн билээ. Монитарист онол нь зөвхөн сонгодог, өрсөлдөөнт, хөгжсөн зах зээлд үнэхээр таардаг, харин манай орон

шиг шилжилтийн үедээ яваа, цөөн тооны монопол үйлдвэр, аж ахуйн нэгж давамгайлсан, шудрага өрсөлдөөн хаагдмал, гадаадаас ихээхэн хамааралтай, жижигхэн зах зээлд үйлчлэхгүй ч байж мэдэх юм.

3. Дүгнэлт, санал

1. Юуны өмнө хямралаас хохирол багатай гарахад чиглэсэн Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд онол, номлолын хувьд зөв, практикт өгөөжтэй байх ёстой. Судалгаанаас үзэхэд хямралын эсрэг авах арга хэмжээний гол тулгуур үзэл баримтлал нь эрэлтийг бүх талаар дэмжихэд л чиглэгдсэн байх нь зүйтэй байна.
2. Их гүрнүүдийн бодлого, эрх ашигтай зөрчилдөж болох жижиг орны үндэсний эрх ашиг, эдийн засгийн бодлогоо хэрхэн зохицуулах асуудалд ч энд хөндөгдөж байна. Ер нь цаашдаа ОУВС-аас тулгадаг шаардлагуудыг өөрийн орны нөхцөлд таарах эсэхийг сайтар тунгаан бодох, шинжиж үзэх шаардлага байгаа юм.
3. Эдийн засаг дахь хөрөнгө оруулалтыг бүх талаар нэмэгдүүлэх бодлогыг явуулах, үүний тулд төв банкны болон арилжааны банкнуудын зээлийн хүүг бууруулах, зээл олголтыг аль болохоор нэмэгдүүлэх шаардлагатай байна. Төсвийн хөрөнгө оруулалтыг ч аль болохоор бууруулахгүй байх нь зүйтэй юм.
4. Арилжааны банкнуудын зээлийн хүүг бууруулах зорилгоор хөрөнгө оруулалт, хөгжлийн банкыг улсын өмч дээр тулгуурлан яаралтай байгуулж, ажиллуулах шаардлагатай байна. Энэ банкууд нь гадаад орноос урт хугацаатай авсан арилжааны зээлийг үйлдвэрлэл эрхлэгчдэд хамгийн бага хүүтэй, урт хугацаатайгаар олгодог байх ёстой.
5. Манай орны хүн амын дунд ядуурал газар авсан онцлогтой тул хямралын үед ядуу өрхийн амьжиргааг тэтгэхэд чиглэсэн арга хэмжээг түлхүү хэрэгжүүлэх шаардлага байна.
6. Улс орны эдийн засгийн хөгжлийн бодлогын асуудлаар Засгийн газарт зөвлөмж өгдөг Үндэсний эдийн засгийн зөвлөл байгуулан ажиллуулахад илүүдэхгүй. Энэхүү зөвлөлийн шугамаар ОУВС-аас явуулж ирсэн бодлогын үр дагаварыг судалж, өөрийн орны нөхцөлд таарах таарахгүйд зөвлөмж өгдөг баймаар байна.
7. Томоохон мөнгөний урсгалыг хянадаг тогтолцоог бий болгох шаардлага байна. Монгол банк, Санхүүийн зохицуулах хороонд ийм эрх мэдлийг хуулиар олговол зохино.
8. Цаашдаа гадаадын хөрөнгө оруулагчдаас хэрэгжүүлэх томоохон төслүүдийн хөрөнгө оруулалтын гэрээг байгуулахдаа оруулсан хөрөнгөө гэнэт их хэмжээгээр татахгүй байх баталгааг маш тодорхой тусгаж өгөх нь зүйтэй байна.

Ашигласан ном, зүй

1. The World Bank quarterly update, March, 2009
2. Ж. М. Кейнс. Общая теория занятости, процента и денег, Москва, 1999
3. Мильтон Фридман, Рөүз Фридман. Хувь заяагаа сонгох нь, Улаанбаатар, 2001
4. Ж. Е. Стиглиц. Дэлхийчлэл ба түүний сэтгэлд эс нийцэх нь, Улаанбаатар, 2007
5. “Дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал ба Монгол Улс” зөвлөлдөх уулзалт дээр тавьсан илтэлүүд
6. Статистикийн бюллетень, 2008 оны 12 сар, 2009 оны 2-р сар.
7. www.pmis.gov.mn